



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/85

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 114 дүгээр
цэцэрлэгийн барилгын бүртгэлийн үнийг
нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 637,979,698 (зургаан зуун гучин долоон сая есөн зуун далан есөн мянга зургаан зуун ерэн найм) төгрөгөөр цэцэрлэгийн барилгын бүртгэлийн үнийг нэмэгдүүлэн бүртгэж авахыг Баянгол дүүргийн 114 дүгээр цэцэрлэг (М.Наранчимэг)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 114 дүгээр цэцэрлэг (М.Наранчимэг)-т үүрэг болгосугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2022 оны 03 дугаар сарын 11 -ны
өдрийн 1/25 дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 114 дүгээр цэцэрлэг

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Цанар байдал	Гүйцэтгэлийн дүн	Хандивлагч байгууллага	
						Нэр	Эх үүсвэр
1	114 дүгээр цэцэрлэгийн барилгын дулаан хамгаалалтын ажил /БГД, 6 дугаар хороо/	Их засвар	2021	сайн	637,979,698	Дэлхийн банкны санхүүжилттэй "Улаанбаатар хотын цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл"	Төсөл, хөтөлбөр
Барилгын бүртгэлийн үнийг нэмэгдүүлэх дүн					637,979,698		